



## Developmental philosophy of education in Mongolia: Research needs and rationale for implementation

Begz Nadmid

### Article information

#### Article history:

Received: 2024.11.04

Revised: 2024.11.18

Accepted: 2024.11.20

#### Keywords:

Rapid changes in society and environment;  
Adapt to changes;  
Human development;  
Lifelong education;  
Foundations of education policy;

### ABSTRACT

We, the Mongolian people, are striving to build and develop a new era of progress in the face of rapid changes in the natural and social environment. One important direction in this endeavor is the reform of education policy. In this presentation, we propose the formulation and implementation of an educational development philosophy as the foundation for Mongolia's new education policy.

Mongolia's education policy has historically been shaped by powerful neighboring nations and the constant influence of dominant foreign cultures, often resulting in the imitation and adaptation of external models. However, if we are to cultivate individuals who meet the demands of the contemporary era through an education system that reflects our own cultural identity, it is imperative to establish a well-founded philosophy of educational development. To reform our education policy, it is crucial to articulate this philosophy in a manner that aligns with international standards while distinctly embodying our national characteristics.

The objective of the current educational development philosophy is to lay the foundation for an education policy that nurtures healthy, well-educated, ethical, creative thinkers, diligent contributors, and globally-aware Mongolians. This should serve as the core of the state policy regarding human development.

### Corresponding author:

Begz Nadmid

Research Sector for Human Development, Mongolian National Institute for Educational Research

Email: [begznadmid@gmail.com](mailto:begznadmid@gmail.com)

## Боловсролын хөгжлийн философийг Монголд судлах хэрэгцээ, хэрэгжүүлэх үндэслэл

Надмидын Бэгз

### Санал болгож буй эшлэл:

Бэгз, Н. (2024). Боловсролын хөгжлийн философийг Монголд судлах хэрэгцээ, хэрэгжүүлэх үндэслэл. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.02>

### To cite this article:

Begz, N. (2024). Developmental philosophy of education in Mongolia: Research needs and rationale for implementation. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.02>

## БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИЙГ МОНГОЛД СУДЛАХ ХЭРЭГЦЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

### ХУРААНГУЙ

Монголчууд бид одоогийн байгаль, нийгмийн орчны хурдтай өөрчлөлтийн нөхцөлд хөгжлийн шинэ үеэ бүтээн байгуулах, хөгжүүлэх эрэл хайгуул хийж байна. Үүний нэг чухал чиглэл нь боловсролын бодлогын шинэчлэл юм. Бид энэ илтгэлдээ монголын боловсролын шинэ бодлогын үндэслэл болох боловсролын хөгжлийн философиийг томъёолж хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

Хүчирхэг хөршүүдтэй, гаднын том соёлын нөлөөнд байнга оршсоор ирсэн монголчуудын боловсролын бодлого нь гаднын хуулбар, дуураймал шинжтэй явж ирсэн юм. Бид одоо хүнийхээ хүмүүжил, боловсролын тогтолцоог өөрийн өнгө аястайгаар хөгжүүлнэ гэвэл шинэ цаг үеийн шаардлагад тэнцэх монгол хүнээ хөгжүүлж төлөвшүүлэх боловсролын хөгжлийн бодлогын философи үндэслэл зайлшгүй нэхэгдэж байна. Боловсролын бодлогоо шинэчлэнэ гэвэл түүний хөгжлийн философиийг олон улсын жишигтэйгээр, өөрийн онцлогтой томъёолох шаардлагатай.

Энэ үеийн боловсролын хөгжлийн философиийн зорилго нь эрүүл, эрдэм боловсролтой, ёсзүйтэй, бүтээлч сэтгэгч, бүтээгч хөдөлмөрч, дэлхийн монгол хүнийг төлөвшүүлэх боловсролын бодлогыг үндэслэх явдал юм. Энэ нь хүнээ хөгжүүлэх талаар манай төрөөс баримтлах бодлогын цөм болох ёстой.

### НЭГ. Боловсролын нийгмийн үүрэг

Оюун ухааны өндөр хөгжилтэй, нийгмийн ухамсартай зохион байгуулалтаар амьдардаг нь биологийн ертөнцөд бусад амьтдаас ялгарах хүний гол ялгаа болдог. Нийгмийн ийм өндөр түвшний зохион байгуулалтаар амьдрахад хүнд хөдөлмөрлөх чадвараас дутуугүй хүмүүжил, ухамсар юуны өмнө хэрэгтэй болдог. Нийгмийн шинэ залуу гишүүдэд үүнийг боловсролоор л эзэмшүүлдэг. Нийгмийн орчин бүхэлдээ хүний хөгжил, төлөвшилд нөлөөлж байдаг тул боловсролыг зөвхөн анги танхимаар хязгаарлаж ойлгох ёсгүй. Учир нь боловсрол, шинжлэх ухаан, урлаг, соёл, хууль цааз, шашин суртахуун бүгд нийлж хүний хүмүүжил, төлөвшлийг тогтооход оролцдог.

Боловсрол хэзээ, ямар хэрэгцээгээр хэрхэн үүссэн нь боловсролын философи, түүхийн судалгааны гол асуудлын нэг байсаар ирсэн юм. Дан байгалийн өгөгдлөөр ямар ч амьтан бие даан оршин тогтнох чадваргүй учир адгуус ч үр зулзагаа амьдрах аргад сургадаг. Хүн тэр тусмаа, нийгмийн шинэ гишүүд өмнөх үеийнхний бий болгосон амьдралын орчинд дасан зохицож, нарийн зохион байгуулалттай нийгмийн харилцааных нь ёс, дэг жаяг, хэм хэмжээг сахиж амьдрахад бэрх. Тийм учир шинэ хүнийг нийгмийн орчинд сургаж дасгах хэрэгтэй болдог. Энэ нь тухайн нийгмийн зохион байгуулалтыг үеэс үед хадгалж, цаашид уламжлуулан хөгжүүлэх бололцоог олгодог. Ингээд бодохоор өнөөгийн бидний боловсрол гэж нэрлэж буй нийгмийн үйл ажиллагаа нь хүний хөгжлийн их эрт үетэй нас ойролцоо байх магадлал өндөр юм.

Боловсрол хэрэгцээнд үндэслэж үүсдэг. Амьдралд хөгжлийн шинэ хандлага үүсэх нь нийгэм, хувь хүний боловсролын хэрэгцээг бий болгодог. Өөрөөр хэлбэл, боловсрол ямар байхыг нийгмийн орчны болон хувь хүний шинэ хэрэгцээ тодорхойлдог гэсэн үг. Иймээс нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсролыг төлөвлөж хөгжүүлэх, түүгээр дамжуулан хүнээ бэлтгэх шаардлага үүсдэг. Тэр хэрэгцээг хангах оюуны болон бусад нөөцтэй байж боловсрол нийгмийн үүргээ хэрэгжүүлнэ. Хэрэгцээг нь гүйцэхгүй хоцорч, нийгмийнхээ захиалгыг биелүүлж чадахгүй болсон боловсролыг хямралд орсон гэж үзэж түүнийг хөгжүүлэх шаардлага үүсдэг. Ийм замаар нийгэмд бий болж буй хэрэгцээг дагаж боловсрол тасралтгүй хувьсан өөрчлөгдөж боловсронгуй болсоор өнөөг хүрч ирсэн гэж үзэж болно. Боловсролын хөгжлийн асуудал биднээс өмнөх олон арав, зуу, мянган үеийнхний анхаарал, сонирхлыг татсаар ирсний дээр шинэ XXI зууны эхээр боловсрол нь хүн төрөлхтний хөгжлийн үндсэн хүчин зүйл, хөдөлгүүр нь, түүний зайлшгүй шаардлагатай орчин болж гарч ирлээ (Н.Бэгз, 2008).

### ХОЁР. Боловсролын судалгааны шинэ үе

Өнгөрсөн зууны сүүлийн хагасаас хүний амьдралын орчин их хурдтай өөрчлөгдөж эхэллээ. Энэ хэрээр түүнийг судлах, цаашдын хандлагыг нь тодруулах нь улам бүр ач холбогдол бүхий, нийгмийн өндөр эрэмбийн оюуны үйл ажиллагаа, мэдлэгийн үйлдвэрлэлийн шинэ чиглэл болж үнэлэгдэж байна. Дээр дурдсанаар өнгөрсөн зууны сүүлч, XXI зууны эхний энэ 20-оод жилийн байдлаас үзэхэд манай гаргийн

байгаль, уур амьсгалын өөрчлөлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил урьдаас тааж таамаглах аргагүй хурдтай хувьсан өөрчлөгдөж байна. Энэхүү тодорхой биш, итгэл найдвар, бас түгшүүр төрүүлэхүйц ойрын бүрхэг ирээдүйн боловсролын асуудал нь шинжлэх ухааны салбарынхны сонирхол татсан, бас ч багагүй санаа зовоосон судалгааны нэг чиглэл боллоо. Үүнд боловсрол судлалын шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг, хариуцлага цаашдаа улам өсөн нэмэгдэх нь тодорхой байна.

Төв Азийн их өндөрлөг талд орших монгол орны нутаг дэвсгэр глобаль дулаарлын сөрөг үр дагаварт хамгийн ихээр өртөж, хуурайшилт, цөлжилт нь хагас нүүдлийн мал аж ахуйд тулгуурласан уламжлалт монгол соёл, иргэншилд том сорилт бэрхшээл болж эхлэв. Хүн ам цөөтэй, мэргэшилтэй ажиллах хүчний хомсдолтой, орчин үеийн үйлдвэрлэлийн техник технологи сул хөгжсөн Монгол орон өнөөдөр өөрийн орны хөгжлийн бүтээн байгуулалтад ч хөрш зэргэлдээх хүчирхэг том үндэстнүүдтэйгээ эн тэнцүү хамтарч ажиллахад улам бүр бэрхшээлтэй болж, гаднын техник-технологийн хараат байдалд улам бүр автсаар байна.

Амьдралын орчин ийнхүү огцом хурдтай өөрчлөгдөж байгаа нь зөвхөн манай орноор хязгаарлахгүй нийт хүн төрөлхтөнд тулгарч буй гамшгийн хэмжээний асуудал болсон тул түүнд дасан зохицож тэсэж үлдэхийн тулд дотоод, гадаад хүчин зүйлсээ дайчлахын зэрэгцээ юуны урд хүнээ хөгжүүлж боловсруулах арга замыг сонгох болов. Энд дурдан буй монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд тулгарч буй сорилтуудыг даван туулах гол арга зам нь ч олон улсын нийтлэг жишигт нийцсэн, өөрийн үндэсний онцлог бүхий, XXI зууны монголын шинэ боловсролыг төлөвлөн хөгжүүлэх явдал байхаар байна.

### **ГУРАВ. Боловсролын хөгжлийн философийн хэрэгцээ**

Монгол Улсад боловсролын философийн судалгаа шинэ тутам. Өмнөх тогтолцооны үед гол төлөв социалист зан үйл, коммунист ёс суртахуунд үндэслэгдсэн ертөнцийг үзэх үзлийн номлол, хүмүүжлийн онолыг хүний хөгжлийн үзэл баримтлал болгож байлаа. Харин “либерал ардчиллын” гэх энэ нөхцөл дэх залуу үеийнхний хүмүүжил, төлөвшлийн үндэс болохуйц үзэл баримтлал манай улсад одоо хэр гараагүй байна. Учир нь монгол хүн гэж хэн юм, түүний менталитет, сурах хэрэгцээ, сурах чадвар бусдын нийтлэгээс юугаараа өөр онцлог гэдгийг судалж тогтоогоогүй тул түүнд тохирсон боловсролын хөгжлийн бодлогыг тодорхойлох бэрхшээлтэй. Ийм учраас дээр дурдсан байгаль, нийгэм, технологийн хурдтай өөрчлөлтийг дагуулан хүний хөгжлийн үндсэн хүчин зүйл болсон боловсролоо төгөлдөршүүлэн хувиргаж авч явах нь манай хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болж тавигдаж байгаа юм.

Шинэ зуун гарангуут дэлхий дахинд технологийн 4 дэх хувьсгалын үйл явц эрчимжиж, улс орнууд боловсролынхоо бодлого төлөвлөлтөд зохих нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлт оруулцгааж байна. Манай хувьд ч гэсэн өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий хөгжлийн хэрэгцээ үүсэж байгаа тул энэ шинэ үеийн боловсролын зорилго, зорилтоо ч мөн л өөрийн онцлогтойгоор тодорхойлох шаардлагатай гэж бодож байна.

Сайн, муугаас сав дүүрдэгчлэн, монгол хүнд байгалиас авч төрсөн сайн, саар олон янзын шинж бий. Үүнийг нарийн сайн тогтоож оношлон, үүнийгээ харгалзан тооцож хүнээ хөгжүүлэх сургалтын бодлого, үйл ажиллагаандаа мөрдөх замын зурагтай байхгүй бол боловсролын зорилгыг томьёолох, хэрэгжүүлэх нь цаашдаа амжилттай болоход хэцүү. Улс үндэстнийг хөгжлийнх нь стратегийн “зорилтот цэгт” хүргэж өгдөг боловсрол хэмээх нүсэр хөлөг онгоцонд зүг чигийг заагч луужин хэрэгтэй. Энэ нь хүнээ хөгжүүлэх боловсролын философи номлол юм. Түүнгүйгээр глобаль соёлын их далайд “бусдын олон арал дунд төөрч”, өвөг дээдсээс хүсжэж мөрөөдсөн хөгжингүй, хүчирхэг үндэстэн болгох тэр зүгт тасралтгүй хөвж хүрэх захиасыг өнөөгийн бид биелүүлж чадахгүйд хүрнэ.

Шинэ зуунд дээрх зорилгыг хэрэгжүүлэх хөгжлийн шинэ хандлага бүхий Монгол Улсын хүн амын боловсролын философи үндэслэлийг томьёолж тодорхойлох нь боловсролын хөгжлийн бодлогыг залуу үеийнхний хүмүүжил төлөвшил, боловсролын шинэ эрэлтэд чиглүүлэн томьёолох үндэслэл болох бөгөөд энэ нь монголын боловсролын философийн хийх ажил гарцаагүй мөн. Бид саяхан хэвлүүлж гаргасан “Монголын боловсролын философи” нэг сэдэвт бүтээлээрээ дээрх зорилгыг шийдвэрлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилго тавьсан бөгөөд өнөөдрийн боломжийн хүрээнд энэ зорилгоо биелүүлсэн гэж үзэж байна.

Өнөөдөр монголын хүний хөгжлийн үзүүлэлтүүд, амьдралын чанар өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад ихээхэн сул дорой байдалтай байгаа. Мөн глобаль соёлын сөрөг нөлөөнд монголчуудын ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлсийн тогтолцоо өмнөхөөс ихээхэн өөрчлөгдлөө. Монголын нийгэм 30-аад жилийн өмнөөс хөгжлийн шинэ хандлагатай болж өөрчлөгдөж эхэлсэн ч одоогоор шинэ хуучны зааг дээр, аль алиных нь давуу болон

сул талыг өөртөө агуулсан холимог шинжтэй хэвээр байна. Энэ тулж ирээд буй оршихуйн шинэ нөхцөл байдлын судалгаанд ихээхэн ач холбогдол өгч, цаашдын хандлага, үйл явцынх нь зүй тогтлыг урьдчилан судалж тодорхойлох, сөрөг үр дагаврыг бууруулах хариу арга хэмжээг төлөвлөх нь боловсролын ирээдүй судлалын төдийгүй манай орны хөгжлийн бодлогын нэг тулгамдсан асуудал болно гэж бодож байна.

Хүчирхэг хөршүүдтэй, гаднын том соёлын нөлөөнд байнга оршсоор ирсэн хүн ам цөөтэй үндэстэн монголчуудын хүмүүжил, боловсролын тогтолцоо хөгжлийн хувьд ээдрээтэй салаа замын уулзварт ирсэн ийм үед бидэнд өөрийн гэсэн, шинэ цаг үеийн шаардлагад тэнцэх монгол хүнээ хөгжүүлж төлөвшүүлэх боловсролын хөгжлийн бодлогын философи үндэслэл зайлшгүй нэхэгдэж байна. Энэ үеийн боловсролын хөгжлийн философийн зорилго нь *эрүүл, эрдэм боловсролтой, ёсзүйтэй, бүтээлч сэтгэгч, бүтээгч хөдөлмөрч, дэлхийн монгол хүнийг төлөвшүүлэх* боловсролын бодлогын үндэс болох явдал мөн. Энэ нь манай төрөөс баримтлах хүний хөгжлийн бодлогын цөм болох ёстой гэж үзэж байна.

### **ДӨРӨВ. Боловсролын хөгжлийн философийг хэрэгжүүлэх аргазүйн асуудал**

Хүний хүсэл, хэрэгцээ хязгааргүй. Харин түүнийг хангах төрөлх биологийн өгөгдөл, бололцоо хязгаарлагдмал нь монгол хүнээ хөгжүүлэх боловсролын зорилгыг тодорхойлох бидний аргазүйн философи үндэслэл болно. Бид олон арван жил өөрсдийн онцлогийг олигтой судалж тогтоолгүйгээр бусдын жишгийг дагаж боловсрол, сургалтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн улс. Гэтэл өөрийгөө таньж мэдэх нь өөрсдийгөө хөгжүүлэх урьдчилсан нөхцөл гэж философийн шинжлэх ухаан үздэг аж. Мөн хүн өөрийгөө таньж мэдэх нь философийн судалгааны эцсийн дээд зорилго хэмээн их сэтгэгч ч бас тэмдэглэжээ (Кассирер, Э. 2016).

Гэвч бид өөрийн монгол үндэстнийхээ мөн чанар, сэтгэлгээний онцлог, менталитетийг шинжлэх ухааны түвшинд таньж мэдэх талаар тун хангалтгүй байдалтай явж ирж гэж би үздэг. Үүнтэй холбогдуулаад бодоход эзэн Чингис хаан *“Иргэнийг хураах гэвэл сэтгэлийг нь хураа. Сэтгэлийг нь хураасан байхад бие нь хаа холдох”* гэж сургасныг манай боловсрол, сургалтынхан хэр мэдэж хэрэгжүүлж ирсэн бол гэх асуудал гардаг. Бид хүнийхээ сэтгэлийг, түүний менталитетийг зөв таньж нөлөөлөхгүй бол түүнийг сургаж хүмүүжүүлэх гэдэг бэрхшээлтэй. Эндээс харсан ч монгол хүний сэтгэцзүйн онцлогийг харгалзаж тооцсон хүний хөгжлийн философи үзэл санаа бидэнд хэрэгтэй байна. Үүнийг боловсролын хөгжлийн философи гэсэн утгаар ойлгох байх гэж найдаж байна. Ер нь боловсролын хөгжлийн бодлогын магнайд түүний философи явдаг бөгөөд боловсролын номлол, боловсролын хөгжлийн үзэл баримтлал дараалах ба эдгээр нь эрэмбээрээ түүнийг хэрэгжүүлэх доод шатны бодлогууд юм. Энэ дарааллаар шинэ зууны монгол хүний хөгжлийн бодлогыг цогц байдлаар бүрдүүлж хэрэгжүүлэх нь ойрын жилийн манай боловсролын салбарын бодлогын судалгаа, бодлого боловсруулалтын тэргүүлэх нэг чиглэл байх ёстой гэж үзэж байна.

Энд ярьж буй боловсролын хөгжлийн философийг боловсруулж хэрэгжүүлэх анхдагч нөхцөл нь дээр дурдсанаар монгол хүний сурах онцлог, түүний сурах чадварын судалгаа юм. Бидний санаачилж 2013 оноос эхлүүлсэн Монголын хүүхэд, залуусын цогц хөгжлийн судалгаа нь алсдаа Монголын боловсролын хөгжлийн философийг боловсруулж хэрэгжүүлэхэд анхдагч нөхцөл нь болж байгаа юм. Энэхүү үргэлжлэх судалгааг 2014-2017, 2019-2022 онд 2 удаа явуулж, дүнг БШУЯ, ШУТС-нд гаргаж өгсөн бөгөөд одоо сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичиг бичих, хүүхэд, залуусын хөгжлийг үнэлэх онол, аргазүйн үндэслэл болж сургалтын практикт хэрэглэгдэж байна. Дараагийн шатны судалгааг 2025-2026 оноос эхлэх шаардлагатай. Хүний хөгжлийн үзүүлэлтийг гаргах энэ төрлийн судалгааг дор хаяж тодорхой давтамжтайгаар 4 удаа хийж байж тухайн үндэстний хүүхэд, залуусын нас насны хөгжлийн жишиг үзүүлэлтийг тогтоодог юм билээ.

Энэ шинэ Мянганы эхэнд монголчууд бид хөгжлийн глобаль орчинд аж төрж байна. Энэ байнга хурдтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа шинэ орчин нь хүн бүрээс бүтээлч өндөр чадварыг шаардах болов. Өөрийгөө тасралтгүй хөгжүүлж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхгүйгээр хувь хүн ч, улс үндэстэн ч цаашид оршин тогтноход халтай нөхцөл байдлыг хөгжлийн глобаль орчин бий болгож байна. Иймд иргэдийн насан туршийн боловсролын тогтолцоог бүрэн утгаар нь буй болгож, хөгжлийн таатай орчныг нь бүрдүүлэхэд төрөөс анхаарч, хүмүүст насны багаас тасралтгүй сурах арга барил эзэмшүүлэх нь өнөө цагийн боловсролын үндсэн зорилго, үүрэг боллоо<sup>1</sup>.

Шинэ зууны техник технологийн шинэ орчинд ажиллаж амьдрахад шаардлагатай математик, мэдээллийн технологи, байгалийн шинжлэлийн ухаан, англи болон дэлхийн бусад том хэлүүдийг сурах нь хүн бүрийн

амьдрах чадварыг дэмжих нэг нөхцөл болж тавигдаж байна. Гадаад орнуудын боловсролын тогтолцоон дахь сургалтын шинэчлэлүүдийг харахад орон бүрийн онцлогтой боловч ерөнхий шинжээрээ энэ л хүрээг хамарсан байгаа нь судлаачдын бүтээлд туссан байна (Katsutoshi Mizuhara ets. 2019). Эдгээр нь бидний амьдарч буй глобаль хөгжлийн орчны шаардлага юм. Мөн хамтарч ажиллах, хамтарч амьдрах, бусдын санаа бодлыг хүндэтгэн хүлээн авах, ойлголцол, зөвшилцлөөр шийдвэр гаргах, тууштай ажил хэрэгч чанар, өөрийн үйл ажиллагааны хариуцлагыг ухамсарлах чадварууд нь монголчууд бидэнд одоо туйлын чухлаар шаардагдаж байгаа ба эдгээр бүтээлч, глобаль чанаруудыг иргэдэд бий болгож хөгжүүлэх нь манай оронд шинэ зууны боловсролыг бий болгож хөгжүүлэхийг зайлшгүй болгож байна.

Монгол Улсад хүмүүнлэг, иргэний нийгэм төлөвшүүлэх нийгмийн үндсэн институт нь манай шинэчлэгдэн хөгжиж байгаа боловсролын тогтолцоо мөн. Ард иргэдийн бие бялдар, оюуны болон нийгмийн хөгжлийг хангаж, тэдний сонголт хийх, өөрийгөө удирдах хэрэгт оролцох идэвхтэй, бүтээлч оролцоог нэмэгдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх зэрэг ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг боловсролоор дамжуулан эзэмшихэд нь иргэдэд төр ямагт тусалж, таатай орчныг бүрдүүлж өгөх нь тус оронд иргэний нийгэм төлөвшүүлж хөгжүүлэх нэг үндсэн урьдач нөхцөл болно. Үүнд залуу хойч үеийг нийгэмшүүлэх, тэднийг ёс зүйтэй, нийгмийн идэвхтэй, бүтээлч иргэн болгон төлөвшүүлэх боловсролын үүрэг маш чухал.

Гэтэл хүний нийгэмд боловсролын гүйцэтгэдэг олон функцийн зөвхөн ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн үүргийг л манайд ярьдаг болсоор удаж байна. Үүнийг лав л сүүлийн 30-аад жилд монголын боловсролын салбарт хөрөнгө оруулсан олон улсын байгууллагууд ихээхэн сурталчилж, манайхан ч түүнийг нь даган баясаж, ажиллах хүчний нөхөн хангалт нь дундын дараах мэргэжлийн боловсролын үндсэн үүрэг мэтээр үнэмшиж, ярьж бичих болов.

Уг нь монголчууд эртнээс нааш хүүхэд залуусаа эрдэм номд сургахаас дутуугүй тэднийг хүн болгон хүмүүжүүлэх боловсролын үүргийг чухалд үзэж ирсэн уламжлалтайг *номыг нь сурахгүй ч номхоныг нь сурах* талаар судар номд бичиж, ард түмэн олон үеэр хэлэлцэж ирснээс харж болно (Монгол ардын цэцэн үг, 1989). Дээр дурдсанаар, боловсролын нийгмийн үүргүүдийн хамгийн чухал ч гэж үзэж болохоор, суралцагчдад шинжлэх ухааны мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхээс дутуугүй тэднийг нийгмийн гишүүн, иргэн болгон хөгжүүлж төлөвшүүлэх үүрэг манайд энэ хугацааны боловсролын бодлогод ихээхэн үгүйлэгдэж буйг тэмдэглэх хэрэгтэй.

Үзэл бодлын ялгарал, өөрийн толгой мэдэлтэй амьдрах сонирхол, шударга ёс, хамтын оюун бодолд тулгуурласан үнэн зөв шийдвэр, өрсөлдөх өндөр чадвар зэрэг нь залуу үеийнхний тодорхой хэсгийн сонголт болж байгаа ч үүнд найдаж, манай нийгэм аяндаа урсгалаараа гаднын сайхан туршлага, жишээгээр өөрөө шинэ зууны хэрэгцээг хангах хэмжээнд хөгжиж төлөвшинө гэж эндүүрч болохгүй. Өнөөгийн барууны гэгдэж байгаа техник, технологийн өндөр хөгжил, ардчилсан хүмүүнлэг нийгмийн хэм хэмжээ, идеал нь гадаадад олон зууны туршид, хүнд бэрх замыг туулж, хатуу сургамжийг үлдээн байж төлөвшсөн, хүн төрөлхтний хөгжлийн нэгэн их үнэт зүйл юм. Түүнийг төлөвшүүлж, хөгжүүлэхэд боловсролын оруулах хувь нэмрийг зөв тооцож, хөгжлийн бодлогыг нь олон улсын нийтлэг жишиг, үндэсний өвөрмөц онцлогийн уулзвар дээр авч явах хариуцлагатай цаг үе одоо та бидний өмнө тулж ирж байна.

## ДҮГНЭЛТ

Манай төрөөс шинэ зууны монгол хүнээ хөгжүүлэх бодлогод юуны өмнө ХХ1 зуунд байгаль, нийгэмд үүсч буй бэрхшээл, сорилтуудыг тууштай сөрөн тэмцэх мэдлэг, чадварыг иргэддээ эзэмшүүлэх асуудал өнөөгийн боловсролын бодлогын тэргүүлэх асуудал байх ёстой. Энэ бол монголын гэлтгүй дэлхий дахинд хүн төрөлхтөн энэ хүнд бэрх үеийг туулан, тэсч үлдэх тухай асуудал болон тавигдаж байна.

Энэ амин чухал том зорилгыг хэрэгжүүлэх нь юуны өмнө боловсролын системийн тулгам асуудал боловч зөвхөн ганц боловсролын гэлтгүй, нийгмийн бусад бүх институтуудийн нэгдсэн хүч бололцоог дайчлан зохион байгуулах нь бодлогыг амжилтад хүргэх бололцоог олгоно. Энэ нь монголын боловсролын ХХ1 зууны хөгжлийн философийг хэр зөв томъёолохоос ихээхэн хамаарна.

Энэ үеийн боловсролын хөгжлийн философийн зорилго нь *эрүүл, эрдэм боловсролтой, ёсзүйтэй, бүтээлч сэтгэгч, бүтээгч хөдөлмөрч, дэлхийн монгол хүнийг төлөвшүүлэх* боловсролын бодлогын үндэс болох явдал юм.

## НОМ ЗҮЙ

Бэгз, Н. (2008). Боловсролын хөгжлийн онол, аргазүйн асуудлууд. Улаанбаатар.

Кассирер, Э.(2016). Хүний соёлын философийн удиртгал. Хүний тухай философи. Улаанбаатар.

Бэгз, Н. (2001). Глобальчлалын үеийн МУ-ын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудлууд. Улаанбаатар.

Монгол ардын цэцэн үг. (1989). Ц.Өлзийхутаг эмхтгэв. Улаанбаатар.

Цанжид, А. (2023). Монголын боловсролын философийг хөгжүүлэх асуудалд. Улаанбаатар.

*Philosophy of Development (Reconstructing the Foundations of Human Development and Education)* Edited by Woutervan Haaffen University of Nijmegen, Michiel Korthals Wageningen Agricultural University, and Thomas Wren Loyola University of Chicago.

Overton, W. F. (2006). Developmental Psychology: Philosophy, Concepts, Methodology. In R. M. Lerner (Ed.) Theoretical models of human development. Volume 1 of the Handbook of Child Psychology (pp. 18-88). (6th ed.), Editor-in-Chief: William Damon; Richard M. Lerner. New York: Wiley.

Katsutoshi Mizuhara ets. (2019) Japanese Citizens Challenge New Learning under the 4th Industrial Revolution. Tohoku University.